

Төмөр зам, Автозамаар татан авах ачаа



Эм, эмнэлгийн хэрэгслийн судалгааг ханган нийлүүлэх байгууллагуудаас сар болгон авч, ГХЯ, ЗТХЯ, УБТЗ-д хүргүүлэн татан авах ажлыг зохион байгуулж байна. 2022 оны 01-08 дугаар сард нийт 399 вагон/чингэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эд, эмнэлгийн тоног төхөөрөмж бүхий ачааны мэдээллийг телеграмм бичгээр болон ноот бичгээр БНХАУ-ын талд хүргүүлжээ.

Ханган нийлүүлэх байгууллагуудын анхааралд:

- Төмөр замаар татан авах шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эд, эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг доорх загварын дагуу ЭЭХХЗГ-т албан бичгээр ирүүлнэ үү.

№	中铁计划预约号	货物品名	需求车	车种	装车站	БНХАУ-д холбоо барих төлөөлөгчийн мэдээлэл
	Төмөр замын захиалгын дугаар	Бараа бүтээгдэхүүний нэр Чингэлэг дугаар	Шаардлагатай галт тэрэгний тоо	Галт тэрэгний төрөл	Боомт	
"Байгууллагын нэр" ХХК, Холбогдох ажилтны нэр, Утас						
1	202209PY123456	药物, 一次性口罩 Эм, нэг удаагийн амны хаалт /TSLU0533668/40'/	1	棚车 Битүү вагон	二连 Эрээн	慕林杰, 手机 : 86-13863101078, 中国外运 Мү Лин Жиэ, утас: 86- 13863101078, Синотранс

*Төмөр замын захиалгын дугаар нь тухайн сар эсхүл ирэх сарын захиалгын дугаар байхыг анхаарна уу. Жишээ нь 09-р сард татан авах шаардлагатай ачааны захиалгын дугаар 202208 эсхүл 202209-аар эхэлсэн захиалгын дугаар байна.

- Авто замаар татан авах шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эд, эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг доорх загварын дагуу ЭЭХХЗГ-т албан бичгээр ирүүлнэ үү.

№	Байгууллагын нэр	Барааны нэр, төрөл	Чингэлгийн дугаар	Байршил, тайлбар	БНХАУ-д холбоо барих төлөөлөгчийн мэдээлэл, хаяг, утасны дугаар
1	 ХХК	тарилгын шингэн	RXCU123456-6	Эрээн боомтын гадна тусгай талбайд	地址：内蒙古锡林郭勒盟二连浩特市 环宇物流园区4号库5号门 联系方式：1234567890 斯日古楞

Агаараар татан авах ачаа

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай, тасалдах эрсдэлтэй, яаралтай татан авах шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эд, эмнэлгийн тоног төхөөрөмж бүхий ачааг МИАТ-тай хамтран боломжит хамгийн ойрын нислэгийн хуваарьт оруулан татан авах ажлыг зохион байгуулж байна.

Нислэгийн хуваарьт оруулах шаардлагатай ачааны мэдээллийг МИАТ-ийн агаарын тээврийн баримт (airway bill)-ын хамт албан бичгээр ирүүлнэ үү.